ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 03 өдөр Дугаар А/12 Мандалговь

"Удам судраа мэдэж,
Угийн бичгээ хөтөлцгөөе"
аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Соёлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь заалт, Монгол Улсын Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоол, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Угийн бичиг хөтлөх"-ийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, ураг төрлийн хүрээгээ тогтоох, угийн бичгээ үнэн зөв хөтөлж сурах, өвлүүлэх, соёлын үнэт зүйлийг уламжлуулах зорилгоор "Удам судраа мэдэж, Угийн бичгээ хөтөлцгөөе" сарын аянг зохион байгуулсугай.

2. "Удам судраа мэдэж, Угийн бичгээ хөтөлцгөөе" аян зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 200.000 (Хоёр зуун мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА Ц.ГАНЗОРИГ

9034137 4910129115

811900